

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 сарын 21

дугаар 01

Шарын гол сум

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2022 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд,

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДСАЙХАН

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 сарын 21

дугаар 02

Шарын гол сум

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДСАЙХАН

2023 оны 4-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын ...дугаартай тогтоолын Хавсралт



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв

| д/д | Зардлын төрөл | НИЙТ ЗАРДАЛ төгрөгөөр |
|-----|-------------------------------------|--------------------------|
| 1 | ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин | 184,380,000 |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 25,919,340 |
| 3 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 33,942,101.90 |
| 4 | Хурлын үйл ажиллагааны бусад зардал | 7,500,000 |
| | Нийт | 251,741,441 |

---o0o---

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023.04.21

дугаар 03

Шарын гол сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт,
хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

Б.Батбаатар

Ц.Тэмүүлэн

Н.Батнайрамдал

Б.Тулга

Б.Мэндсайхан

Б.Пүрэвбаатар

Хараат бус гишүүнд

Г.Хулан

Б.Итгэл

Ж.Эрдэнэбат

нарыг

2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДСАЙХАН

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023.04.21

дугаар 01

Шарын гол сум

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагаас 15 цагийн хооронд Дархан-Уул аймаг Шарын гол сум санжинт 3-р баг Шарын гол ХК-ийн өөрийн байр, 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хурлын эхэнд Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй оролцогчдын ирцийг тооллогын комисс нэгтгэн гаргаж “хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” ХЭХ-ын тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг комиссын дарга /Г.Өэлүн/ уншиж танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 12,423,825 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 11,213,866 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 90.2 хувь нь хуралд ирснийг мэдээлж, Компанийн тухай хуулийн 69,1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4-ийн 7 дахь заалтын дагуу энэхүү ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг уг тогтоолд дурдсан байна.

Хурлын дарга ТУЗ-ийн дарга Г.Хулан ажлын шаардлагаар Сингапурт улсад ажиллах болсонтой холбогдуулан, хурлын даргыг өөрчлөн гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан хурлыг даргалахаар болсон.

Хурлын дарга Б.Мэндсайхан Хуралд ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд баярласнаа илэрхийлье. Хурлын ирц хуульд заасан хэмжээнд хүрч байгаа тул хурлын үйл ажиллагааг нээж байна. Хурлын хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хурлаас 3, тогтоол гаргах байгаа бөгөөд. Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлуудыг хэлэлцэн батална. Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан үйл ажиллагааны тайлан, Ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлт, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван ТУЗ төсөв, засаглалын тайлангийн талаарх танилцуулгыг хийж, дараа нь асуулт хариултын үе шат явж, санал авахаар завсарлан, дараа нь санал тооллогын дүнг танилцуулж, хурлаас гарах тогтоолыг уншиж сонгосноор дуусна.

1.ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай”

-**Хурлын дарга:** 2022 оны үйл ажиллагааны талаар дэлгэцэнд холбогдох мэдээллийг харуулан дэлгэрэнгүй танилцуулгыг хийв.

-**Ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал:** 2022 оны санхүүгийн тайлангийн талаар дэлгэцэнд холбогдох мэдээллийг харуулан дэлгэрэнгүй танилцуулга хийв.

-ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван: 2022 оны ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурал, гаргасан шийдвэр, засаглалын талаар дэлгэрэнгүй тайлбарлан танилцуулав.

Ө.Энхтайван: Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, тодруулах зүйл та бүхэнд байна уу гэхэд асуулт асуух хүн гарсангүй.

2.ХЭЛЭЛЦСЭН НЬ: ”Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай”

Ө.Энхтайван-Хурлаас гарах тогтоолын төсөлтэй та бүхэн танилцана уу гэв. Эндээс тодруулах асуулт байна уу гэхэд хуралд оролцогчдоос асуулт байхгүй гэв.

3.ХЭЛЭЛЦСЭН НЬ: ”Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”

Ө.Энхтайван-Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байна уу гэж асуухад, асуулт гарсангүй.

Хурлын дарга-Хэлэлцэх асуудлын танилцуулга, асуулт хариулт явж дууссан тул одоо хувьцаа эзэмшигч та бүхэн хэлэлцэх асуудлаар саналаа өгнө, тооллогын комисс саналыг тоолох хугацаанд хурлын үйл ажиллагаа түр завсарлаж, тооллогын комисс тогтоолоо танилцуулснаар хурал үргэлжилнэ гэв.

Түр завсарлага 10 минут болов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлсэн дүнг нэгтгэсэн тул хурал үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Г.Өэлүн тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав. Тус хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрийн зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо хувь, тооллогын комиссын тогтоол дугаар 02, 03, 04 -г уншиж танилцуулав. Үүнд:

| д/д | Хэлэлцсэн асуудал | Санал | | | |
|-----|---|------------|------------|------------|------|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Хувь |
| 1 | Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах | 11,213,866 | | | 100% |
| 2 | Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах | 11,213,866 | | | 100% |

| 1. | Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох | Санал өгөх эрх | Санал өгсөн эрх | Хувь |
|----------------------|------------------------------------|----------------|-----------------|-------|
| а) Ердийн гишүүд | | | | |
| | Б.Батбаатар | 100,924,794 | 11,411,839 | 11.3% |
| | Б.Мэндсайхан | 100,924,794 | 11,411,889 | 11.3% |
| | Т.Говьдэлгэр | 100,924,794 | - | 0.00% |
| | Б.Тулга | 100,924,794 | 13,699,813 | 13.5% |
| | Б.Пүрэвбаатар | 100,924,794 | 11,411,789 | 11.3% |
| | Ц.Тэмүүлэн | 100,924,794 | 11,411,689 | 11.3% |
| | Х.Уянга | 100,924,794 | - | 0.00% |
| | Н.Батнайрамдал | 100,924,794 | 11,411,737 | 11.3% |
| б) Хараат бус гишүүд | | | | |
| | Г.Хулан | 100,924,794 | 10,055,401 | 9.9% |
| | Ж.Эрдэнэбат | 100,924,794 | 10,055,346 | 9.9% |
| | Б.Итгэл | 100,924,794 | 10,055,291 | 9.9% |

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолуудын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван уншиж сонгов. Үүнд:

1. “Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах”
 2. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах”
 3. “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”
- Эдгээр тогтоол болно. /тогтоолуудыг хавсаргав/

Хурлаас гарах тогтоолын төслүүдийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асууж, Хурлын үйл ажиллагааг хаав.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН



Ө.ЭНХТАЙВАН

Б.МЭНДСАЙХАН